

ИХЭР МӨРӨН АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шинэ-Идэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/140/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум 2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал, аудитор Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaa@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мерен сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2023.08.24 № 01/108
танай _____-ны № _____-т

ШИНЭ-ИДЭР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ю.ЦЭНГЭЛМӨРӨН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинэ-Идэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинэ-Идэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгө данс 70,272.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сургуулийн захирал Шинэ-Идэр сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг төлөвлөж, 88.9 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
УИХ	Улсын их хурал
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	156,230,519.00	235,152,683.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	70,272,833.00
3121	Төгрөг	00.00	70,272,833.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	70,272,833.00
33	АВЛАГА	00.00	70,272,833.00
335	Бусад авлага	00.00	13,863,900.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	13,863,900.00
34	УРЬДЧИЛГАА	00.00	13,863,900.00
34600	Урьдчилж гарсан зардал	00.00	2,640,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	00.00	2,640,000.00
351	Түүхий эд материал	156,230,519.00	148,375,950.00
35130	Эм боох материал	1,404,310.00	900,140.00
354	Хангамжийн материал	1,404,310.00	900,140.00
35410	Бичиг хэргийн материал	154,826,209.00	147,475,810.00
35460	Хүнсний материал	102,000.00	109,000.00
35470	Бусад хангамжийн материал	25,748,465.00	16,109,195.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,878,911,755.16	4,723,997,113.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,878,911,755.16	4,723,997,113.92
392	Биет хөрөнгө	4,787,545,755.04	4,633,236,113.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,748,577,410.34	4,748,577,410.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	-270,227,814.78	-408,813,015.78
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,000,000.00	23,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-23,000,000.00	-23,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	219,144,300.00	266,229,549.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-62,295,805.94	-125,069,673.03
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	146,770,835.52	153,035,140.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	-55,762,947.35	-75,314,012.55
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	25,000,000.00	25,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	16,993,569.00	28,693,569.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-13,968,867.75	-16,493,569.07
39217	Ном	33,315,076.00	37,390,715.00
393	Биет бус хөрөнгө	91,366,000.12	90,761,000.08
39301	Програм хангамж	3,025,000.00	3,025,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-344,999.88	-949,999.92
39303	Бусад биет бус хөрөнгө	88,686,000.00	88,686,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,035,142,274.16	4,959,149,796.92
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,035,142,274.16	4,959,149,796.92
51	Засгийн газрын хувь оролцоо	5,035,142,274.16	4,959,149,796.92
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	899,680,530.00	899,680,530.00
51101	Өмч: - төрийн	899,680,530.00	899,680,530.00
512	Хуримтлагдсан үр дүн	3,403,097,918.18	3,327,105,440.94
51210	Өмнөх үеийн үр дүн	3,403,097,918.18	3,403,097,918.18
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-75,992,477.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	732,363,825.98	732,363,825.98
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,035,142,274.16	4,959,149,796.92

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,229,917,732.88	1,688,474,824.41
120	Нийтлэг татварын бус орлого	2,903,809,258.52	46,982,224.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,903,809,258.52	46,982,224.41
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,803,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,903,809,258.52	44,178,424.41
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	307,949,174.36	1,641,492,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,255,156,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,255,156,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	300,955,500.00	386,336,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	300,955,500.00	386,336,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,459,602,292.16	1,764,467,301.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,459,602,292.16	1,764,467,301.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,391,610,869.16	1,683,154,457.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	793,846,843.00	920,058,261.00
210101	Үндсэн цалин	793,846,843.00	656,892,004.00
210102	Нэмэгдэл	00.00	205,211,972.00
210104	Урамшуулал	00.00	57,954,285.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,491,438.00	116,685,836.00
210201	Тэтгэврийн даатгал	71,545,038.00	79,848,077.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,986,600.00	9,214,253.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,389,300.00	7,366,481.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,597,300.00	1,840,599.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,973,200.00	18,416,426.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	281,324,298.00	311,985,925.00
210301	Гэрэл, цахилгаан	6,498,068.00	10,845,390.00
210302	Түлш, халаалт	274,826,230.00	299,807,535.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	1,333,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,196,809.00	15,895,335.00
210401	Бичиг хэрэг	1,101,100.00	1,882,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,145,035.00	4,439,785.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,084,583.00	971,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,466,091.00	3,309,000.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	5,293,150.00
2105	Нормативт зардал	27,262,985.00	67,468,766.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,156,220.00	734,470.00
210502	Хоол, хүнс	25,036,765.00	66,374,296.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	70,000.00	360,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,765,800.00	3,397,260.00
210604	Урсгал засвар	4,765,800.00	3,397,260.00
2107	Томилолт, зочны зардал	294,000.00	252,000.00
210702	Дотоод албан томилолт	294,000.00	252,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,231,138.00	6,206,240.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,631,138.00	3,236,240.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	840,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	2,130,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	160,197,558.16	241,204,834.65
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	6,752,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,848,400.36	10,413,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153,349,157.80	224,039,834.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,991,423.00	81,312,844.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,239,695.00	68,859,629.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,839,695.00	58,200,229.00
		400,000.00	10,659,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,673,402.00	12,453,215.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,673,402.00	12,453,215.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,770,315,440.72	-75,992,477.24
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,754,405,232.38	-75,992,477.24

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,326,108,474.36	1,644,296,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	2,803,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	2,803,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,803,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,326,108,474.36	1,641,492,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,255,156,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,255,156,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	300,955,500.00	386,336,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	300,955,500.00	386,336,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,295,833,474.36	1,542,539,649.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,295,833,474.36	1,542,539,649.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,231,099,256.36	1,461,268,994.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	793,846,843.00	920,058,261.00
210101	Үндсэн цалин	546,443,176.00	656,892,004.00
210102	Нэмэгдэл	200,403,667.00	205,211,972.00
210104	Урамшуулал	47,000,000.00	57,954,285.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,491,438.00	116,685,836.00
210201	Тэтгэврийн даатгал	71,545,038.00	79,848,077.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,986,600.00	9,214,253.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,389,300.00	7,366,481.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,597,300.00	1,840,599.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,973,200.00	18,416,426.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	278,516,298.00	311,985,925.00
210301	Гэрэл, цахилгаан	6,498,068.00	10,845,390.00
210302	Түлш, халаалт	272,018,230.00	299,807,535.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	1,333,000.00
2105	Нормативт зардал	23,900,330.00	55,438,415.00
210502	Хоол, хүнс	22,132,130.00	55,438,415.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,775,800.00	3,397,260.00
210604	Урсгал засвар	4,765,800.00	3,397,260.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,511,138.00	4,933,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,911,138.00	2,803,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	2,130,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,665,300.00	48,769,497.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	36,606,447.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,665,300.00	12,163,050.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,734,218.00	81,270,655.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,982,490.00	68,817,440.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,582,490.00	58,158,040.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	10,659,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,673,402.00	12,453,215.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,673,402.00	12,453,215.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>30,275,000.00</u>	<u>101,756,751.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	30,275,000.00	31,483,918.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,275,000.00	31,483,918.00
2200	Дотоод эх үүсвэрээр	30,275,000.00	31,483,918.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	30,275,000.00	31,483,918.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-30,275,000.00</u>	<u>-31,483,918.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	70,272,833.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	70,272,833.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	899,680,530.00	732,363,825.98	3,403,097,918.18	5,035,142,274.16
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	899,680,530.00	732,363,825.98	3,403,097,918.18	5,035,142,274.16
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-75,992,477.24	-75,992,477.24
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	899,680,530.00	732,363,825.98	3,327,105,440.94	4,959,149,796.92

2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
				Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,257,960,000	1,187,687,167	70,272,833	95.0
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,257,960,000	1,187,687,167	70,272,833	95.0
210	Бараа, үйлчилгээний зардал	1,187,661,700	1,118,869,727	70,272,833	94.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	906,714,800	868,058,261	38,656,539	96.0
210101	Үндсэн цалин	688,963,300	611,734,887	77,228,413	88.7
210102	Нэмэгдэл	184,170,500	201,523,482	-	111.4
210104	Урамшуулал	33,581,000	54,799,892	-	172.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,339,300	110,185,836	3,153,464	97.4
210201	Тэтгэврийн даатгал	77,070,800	75,428,077	1,642,723	98.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,067,200	8,694,253	372,947	96.1
210203	ҮОМШӨ ний даатгал	7,253,700	6,950,481	303,219	96.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,813,400	1,736,599	76,801	96.0
210205	Эрүүл мэндийн даатгал	18,134,200	17,376,426	757,774	96.0
2105	Нормативт зардал	72,759,700	55,438,415	17,321,285	76.2
210502	Хоол, хүнс	72,759,700	55,438,415	17,321,285	76.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	11,003,300	4,933,800	6,069,500	44.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,803,800	2,803,800	-	100.0
210806	Мэдээллийн технологийн зардал	8,199,500	2,130,000	6,069,500	26.0
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	83,844,600	80,253,415	3,591,185	95.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,545,400	68,090,365	3,455,035	95.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,299,200	12,163,050	136,150	98.9
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,298,300	68,817,440	1,480,860	97.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,298,300	68,817,440	1,480,860	97.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	59,638,900	58,158,040	1,480,860	97.5
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	10,659,400	10,659,400	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,257,960,000	1,257,960,000		99.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,255,156,200	1,255,156,200		100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,255,156,200	1,255,156,200	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,803,800	2,803,800	-	100.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,803,800	2,803,800	-	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	70,272,833	70,272,833	-

6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	-	-	-	-
620001	Удирдах ажилтан	66.00	66.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	1.00	1.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	37.00	37.00	-	100.0
		28.00	28.00	-	100.0

2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсөв/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
				Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	386,336,400.00	373,883,185.00	12,453,215.00	
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	386,336,400.00	373,883,185.00	12,453,215.00	
210	Бараа, үйлчилгээний зардал	386,336,400.00	373,883,185.00	12,453,215.00	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	52,000,000.00	52,000,000.00		
210101	Үндсэн цалин	52,000,000.00	45,157,117.00	6,842,883.00	86.8
210102	Нэмэгдэл	-	3,688,490.00	-3,688,490.00	-
210104	Урамшуулал	-	3,154,393.00	-3,154,393.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,500,000.00	6,500,000.00		
210201	Тэтгэврийн даатгал	4,420,000.00	4,420,000.00		100.0
210202	Тэтгэмжийн даатгал	520,000.00	520,000.00		100.0
210203	ҮОМШӨ ний даатгал	416,000.00	416,000.00		100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	104,000.00	104,000.00		100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	1,040,000.00	1,040,000.00		100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	314,836,400.00	311,985,925.00	2,850,475.00	
210301	Гэрэл цахилгаан	13,000,000.00	10,845,390.00	2,154,610.00	
210302	Түлш, халаалт	299,836,400.00	299,807,535.00	28,865.00	
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	1,333,000.00	667,000.00	
2106	Эд хогшил худалдан авах	13,000,000.00	3,397,260.00	9,602,740.00	
	Урсгал засвар	13,000,000.00	3,397,260.00	9,602,740.00	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	386,336,400.00	373,883,185.00	12,453,215.00	
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	386,336,400.00	373,883,185.00	12,453,215.00	96.78
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

1.6.1 Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Шинэ-Идэр сумын ерөнхий боловсролын сургууль нь бага болон суурь, дунд боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулдаг Боловсрол Шинжлэх Ухааны Яамны харьяа байгууллага юм.

Сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

2022 онд “Эрүүл зөв дадал, эерэг хандлага, бүтээлч оролцоог хэвшүүлж сургалтын чанарыг дээшлүүлнэ” гэсэн зорилго тавьж ажилласан ба энэхүү зорилгын хүрээнд багш, сургууль, суралцагч, эцэг эхийн хөгжилд чиглэсэн зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Сургуулийн захирал Шинэ-Идэр сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг төлөвлөж, 88.9 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, “хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.
4. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:
 - Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулсан ба 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан байна.
 - Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн

- тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр", "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал" баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
 - БШУС-ын 2022 оны А/170 дүгээр тушаалаар "төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар"-ыг 1 дүгээр, "багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар"-ыг 2 дугаар, "цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ыг 3 дугаар, "тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар "Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар"-ыг баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
 - БШУС-ын 2022 оны А/452 дугаар тушаал "Хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын тухай"
 - БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаал " Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам"
 - БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу сургуулийн захирлын 2021 оны А/03 тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 1 дүгээр сард батлуулан, тухайн онд нийт 5 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлж, тайлагнасан боловч дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, хяналтаар илрүүлсэн зөрчил, дутагдлыг арилгахад чиглэсэн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна гэж үзлээ.

Түүнчлэн 2022 онд сургуулийн захирлын тушаалаар шинээр гарсан дүрэм, журмуудын хэрэгжилтийг хангах, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсөв санхүүг зарцуулах, түүнд хяналт тавих, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, шинээр гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий зөвлөл, ажлын хэсэг, багуудыг томилж ажиллуулсан байна.

Тус сургууль нь 2022 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулсан байна.

Эдгээр зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны дотоод хяналтын 1 ба 2 дугаар үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний

үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2019-2021 онуудын тайланд нийцлийн аудит хийсэн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шинэ-Идэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа БСШУС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэнтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шинэ-Идэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 75,992.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	-	70,272.8	70,272.8
Авлага	-	13,863.9	13,863.9
Урьдчилж гарсан зардал		2,640.0	2,640.0
Бараа материал	156,230.5	148,376.0	(7,854.5)
Үндсэн хөрөнгө	4,878,911.8	4,723,997.1	(154,914.7)
Нийт хөрөнгө	5,035,142.3	4,959,149.8	(75,992.5)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,035,142.3	4,959,149.8	(75,992.5)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,035,142.3	4,959,149.8	(75,992.5)

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал өмнөх оноос нэмэгдэж, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 70,272.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 7,854.5 мянган төгрөгөөр буурахад түлээний нөөц нэмэгдсэн /түлээний үнийн өсөлт/ нөлөөлсөн байна.
3. Авлага дансны үлдэгдэл 13,863.9 мянган төгрөг байгаа нь тайлант онд нийлүүлэгдээгүй тоног төхөөрөмжийн авлага байна.
4. Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 2,640.0 мянган төгрөг байгаа нь он дамжин хэрэгжих модуль сургалтын төлбөрийн тооцоо байна.
5. Үндсэн хөрөнгө данс 154,914.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 69,125.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, үндсэн хөрөнгийн элэгдэл 224,039.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.
6. Засгийн газрын хувь оролцоо данс 75,992.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улсын төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,251,837.5 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн ба төсвийн төслийн саналаас 143,479.5 мянган төгрөгөөр бууруулан 1,108,358.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Байгууллагын 2022 оны төсвийн төлөвлөлтийг зардлын эдийн засгийн ангиллаар төлөвлөснийг УИХ-аар үр дүн, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт олгохоор баталсантай холбоотой, төсвийн жилийн дундуур төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр удаа дараа нэмэгдүүлэн баталсан байна. Үүнд: БШУС-ын 2022 оны 03 дугаар сарын 24-ны А/105 тоот тушаал, 2022 оны 10 дугаар сарын 7-ний өдрийн А/258 дугаар тушаал, 12 дугаар сарын 30-ны өдрийн А/392 тоот тушаалаар тус тус өөрчлөлт оруулж, анхны баталсан төсвийг 146,798.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлжээ.

Ингэснээр нийт төсвийн зарлагыг 1,257,960.0 мянган төгрөгөөр, үүнээс 1,255,156.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэх, 2,803.8 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвөөс 327,339.2 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, Шинэ-Идэр сумын ЗДТГ-т хүргүүлсэн байна.

Шинэ-Идэр сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 04 тоот тогтоолоор төлөвлөсөн дүнг 467,815.9 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн төсөлд зөвхөн байр ашиглалтын тогтмол зардлаар тооцоолсныг байр ашиглалтын үйлчилгээний зардлыг нэмж баталсантай холбоотой.

Шинэ-Идэр сумын ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 02 тоот тогтоолоор тус сургуулийн төсөвт тодотгол хийж 81,479.5 мянган төгрөгөөр бууруулан, 386,336.4 мянган төгрөгөөр баталсан нь төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин, шимтгэлийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсонтой холбоотой.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,255,156.2 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч 1,184,883.4 мянган төгрөгийг зарцуулж 70,272.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, орон

нутгийн төсвөөс 386,336.4 мянган төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 12,453.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлого 2,803.8 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2,803.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн нь 100.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,561,570.4 мянган төгрөг буюу 95.0 хувь байгаа нь бараа үйлчилгээний зардлын төсвийг 82,726.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	3,279.8	3,279.8		100
2	80312-Сургалт семинар	1,639.9	372.8	1,267.2	22.7
3	81605-Эрүүл мэндийг дэмжих	3,771.8	2,572.0	1,199.8	68.2
4	81801-Үдийн цай хөтөлбөр	59,638.9	58,158.0	1,480.9	97.5
5	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	41,960.0	41,732.9	227.1	99.4
	81806-Дотуур байр	122,151.8	103,646.6	18,505.2	84.8
6	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	7,379.5	6,907.9	471.6	93.6
7	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	849,455.3	813,831.3	35,624.0	95.8
8	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	165,879.2	154,382.1	11,497.1	93.1
9	81848-Сурах бичгийн түрээс	2,803.8	2,803.8		100
Дүн		1,257,960.0	1,187,687.2	70,272.8	94.4
Орон нутгийн төсвөөс					
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	327,836.4	315,383.2	12,453.2	96.2
2	80112-Нийтлэг үйлчилгээ	58,500.0	58,500.0	0.00	100.00
Дүн		386,336.4	373,883.2	12,453.2	96.8
Нийт дүн		1,293,688.30	1,285,110.52	8,577.78	99.34

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шинэ-Идэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн

байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн аудитор Б.Мядагмаа гүйцэтгэж, анхан шатын хяналтыг аудитор Ц.Мөнхтуяа хийж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Шинэ-Идэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,459,602.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 29,192.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд төсвийн байгууллагын авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 30 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хэмнэлтийн горимыг баримталж, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дагавар нь төрийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг бууруулахгүй байх зарчмыг баримтлан ажилласан ба улсын төсвийн мэдээлэл технологийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлаас 70,272.8 мянган төгрөг хэмнэж дансны үлдэгдлээр үлдсэн, орон нутгийн төсвөөс гэрэл цахилгаан, урсгал засварын зардлаас 12,453.2 мянган төгрөгийг хэмнэж орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторовн дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шинэ-Идэр сумын ерөнхий боловсролын сургуулийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд 2022 онд нийт 151 мэдээлэл оруулахаас 1 мэдээлэл хугацаа хоцроож, 145 мэдээлэл хугацаандаа мэдээлж, 5 мэдээллийг оруулах хугацаа болоогүй байна. Байгууллагын 2022 оны батлагдсан төсвийн мэдээлэл нь мэдээлбэл зохих 1 дүгээр сарын 10-ны өдөр дээд шатны төсөв захирагчаас ирээгүй байсан нь хугацаа хоцрох шалтгаан болсон байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Шинэ-Идэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Нийт дүн	1	-	1	-	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар төсвийн жил дамжин хэрэгжиж байгаа сургалтын үйл ажиллагаа, хувьсах зардлын нөхөн хангалтаар авч байгаа тоног төхөөрөмжийг хүлээн авч, орлогод авсан эсэх, сургуулийн үйл ажиллагаанд ашиглахаар худалдан авч байгаа сургуулийн удирдлагын цогц системийн ашиглалтад анхаарах шаардлагатай гэж үзлээ.

Харилцах дансны үлдэгдлийн 70,272.8 мянган төгрөгийн зарцуулалтыг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 46,765.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 20,734.4 мянган төгрөгийн алдааг залруулж, санхүүгийн тайлантай холбоотой 25,031.1 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах нягтлан бодох бүртгэлийн залруулгыг хийсэн болно. Үүнд:

- Бараа материалын тодруулгад 2,570.5 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг бусад хангамжийн материал дансанд бүртгэснийг бичиг хэргийн материал дансанд бүртгэж залруулсан.
- Саммит, Ай Ти Зон компаниудаас 2 нэр төрлийн 13,863.9 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж нийлүүлэгдээгүй байхад үндсэн хөрөнгөнд орлого авсныг авлагаар залруулан бүртгэсэн.
- Он дамжин хэрэгжих багшийн хөгжлийг дэмжих модуль сургалтын төлбөр 4,300.0 мянган төгрөгийг аккруэл сууриар бүртгээгүй, тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэснийг урьдчилж төлсөн зардал дансанд залруулан бүртгэсэн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Дотуур байрны зардлаас аудитын төлбөрийг шилжүүлсэн нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91-р тогтоолоор баталсан зардлын зориулалт, арга хэмжээ, нормативын дагуу төсвийг зарцуулаагүй нь Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зардлын зориулалт, арга хэмжээ, нормативын дагуу төсвийг зарцуулж ажиллах.

2. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдан авалтын анхан шатны төлбөрийн баримтгүй 11,047.1 мянган төгрөгийн 17 ажил гүйлгээ хийж бүртгэсэн нь Аж ахуйн нэгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай

баримтаар баталгаажсан байх” заалттай нийцэхгүй Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалт хийх бүрд давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт авч анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллаж байх.

3. Нормативт зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үдийн хоол, дотуур байрны сурагчдын хоолны зардлыг ирцийн дүн, зарцуулсан хүнсний материалын дүнд нормативаар тооцон үзэхэд дотуур байрны хоолны зардал 9,985.4 мянган төгрөг, үдийн хоол 3,998.6 мянган төгрөгийн хэмнэлттэй 1 хүүхдэд ногдох өдрийн батлагдсан нормативт хүрэхгүй байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолын 2 дахь заалт, 2021 оны 237 дугаар тогтоолын 1 дэх заалттай нийцэхгүй Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сургуулийн үдийн хоол болон дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг батлагдсан нормативын дагуу зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн тодруулагатай холбоотой	1	2,570.5			1	2,570.5	1	2,570.5				
Биетээр байхгүй хөрөнгө бүртгэсэн	1	13,863.9			1	13,863.9	1	13,863.9				
Сургалтын төлбөр буруу бүртгэсэн	1	4,300.0			1	4,300.0	1	4,300.0				
Дүн	3	20,734.4			3	20,734.4	3	20,734.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/ Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Худалдан авалтын анхан шатны төлбөрийн баримтгүй 11,047.1 мянган төгрөгийн 17 ажил гүйлгээ хийж бүртгэсэн	1	11,047.1					1	11,047.1				
1 хүүхдэд ногдох өдрийн батлагдсан нормативт хүрэхгүй байна.	1	13,984.1					1	13,984.1				
Дүн	1	25,031.1					1	25,031.1				